

2024 оны 02 сарын 07 өдөр

Дугаар 09

Улаанбаатар хот

**Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэд
Тогтвортой хөгжлийн хороо байгуулах,
хороодын бүрэлдэхүүнийг томилох тухай**

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.13, 76.1.18 дахь заалт, 81 дүгээр зүйлийн 81.3 дахь хэсэг, Банкны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3.1, 31.3.7 дахь заалт, “Худалдаа, хөгжлийн банк ХК-ийн дүрэм”-ийн 8 дугаар зүйлийн 8.11.21, 8.11.24, 8.11.26 дахь заалтыг тус тус үндэслэн Худалдаа, хөгжлийн банкны Төлөөлөн удирдах зөвлөлөөс **ТОГТООХ нь:**

1. Худалдаа, хөгжлийн банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэд Тогтвортой хөгжлийн хороог байгуулсугай.

2. Тогтвортой хөгжлийн хороог дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай.

Хорооны дарга:	Рандолф Коппа	– Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга;
Хорооны гишүүд:	Н.Сэргэлэн	– Олон улсын банкны газрын харьяа Гадаад эх үүсвэрийн удирдлага, хяналтын хэлтсийн захирал;
	Г.Чимидбалдир	– Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Ажлын албаны Олон улсын хамтын ажиллагаа болон Байгаль орчин, нийгэм, засаглал хариуцсан зөвлөх.
Хорооны нарийн бичгийн дарга:	Н.Сэргэлэн	– Олон улсын банкны газрын харьяа Гадаад эх үүсвэрийн удирдлага, хяналтын хэлтсийн захирал;
	Г.Чимидбалдир	– Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Ажлын албаны Олон улсын хамтын ажиллагаа болон Байгаль орчин, нийгэм, засаглал хариуцсан зөвлөх.

3. Тогтвортой хөгжлийн хорооны зохистой бүтэц, бүрэлдэхүүний талаар судалгааг хийх, тус хорооны үйл ажиллагааны бодлого, журмыг боловсруулан Төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулж, батлуулахыг Тогтвортой хөгжлийн хороо (Рандолф Коппа)-д үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Randolph S. Koppa
РАНДОЛФ КОППА

2024 оны 02 сарын 07 өдөр

Дугаар 10


Улаанбаатар хот

**Худалдаа, хөгжлийн банк ХК-ийн бүтэц, зохион байгуулалтад
нэмэлт, өөрчлөлт оруулах тухай**

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18 дахь заалт, Банкны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3.1 дэх заалт болон “Худалдаа, хөгжлийн банк ХК-ийн дүрэм”-ийн 8 дугаар зүйлийн 8.11.2 дахь заалт, Худалдаа, хөгжлийн банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Цалин, урамшууллын болон нэр дэвшүүлэх хорооны 2023 оны 10 дугаар сарын 6-ны өдөр болон 2024 оны 1 дүгээр сарын 23-ны өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн Худалдаа, хөгжлийн банкны Төлөөлөн удирдах зөвлөлөөс **ТОГТООХ нь:**


1. “Худалдаа, хөгжлийн банк ХК-ийн удирдлага, зохион байгуулалтын бүтэц”-ийг энэхүү тогтоолын хавсралтын дагуу шинэчлэн баталсугай.
2. Энэхүү тогтоолыг 2024 оны 2 дугаар сарын 8-ны өдрөөс эхлэн мөрдөж ажиллах, дотоод зохион байгуулалтыг хийхийг Гүйцэтгэх захирал (О.Орхон)-д үүрэг болгосугай.
3. Энэхүү өөрчлөлттэй холбогдуулан Худалдаа, хөгжлийн банканд мөрдөгдөж буй холбогдох заавар, журмуудад нэмэлт, өөрчлөлт оруулахыг Гүйцэтгэх захирал (О.Орхон)-д даалгасугай.
4. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн 86 тоот тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА




РАНДОЛФ КОППА

TRADE AND DEVELOPMENT BANK OF MONGOLIA ORGANIZATIONAL STRUCTURE



ХУДАЛДАА, ХӨГЖЛИЙН БАНК ХК-ИЙН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

